

## Хулгайгаар алт олборлолт ба шийтгэл

Албан бусаар буюу хулгайн аргаар алт олборлож байгаа иргэд, хүүхдүүд болон зөвшөөрөлтэй уурхайн харуул хамгаалалт, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хооронд нилээд хүндрэлтэй харьцаа үүсдэг байна. Албан бусаар алт олборлож байгаа хүмүүсийн боловсролын түвшин доогуур, амьжиргаас ядуу байгаагаас торгууль ноогдуулахад санхүүгийн баримт шаардаж мэддэггүй, тодорхой хугацааар саатуулгадж байхдаа зодуулах, олсон алтаа дээрэмдүүлэх, эд зүйлсээ эвдүүлэх, хэл амаар доромжуулах зэргийг амсдаг байна.

Зүй бусаар хүч хэрэглэж шийтгэдэг гэж баригдсан хүүхдүүдийн 44.4 хувь нь хариулжээ. Мөн ажил хийлгэдэг гэж баригдсан хүүхдүүдийн 31.9 хувь нь хариулсан ба цагдаа нарын хувцсыг угаах, өрөө цэвэрлэх, хог түүх, түлээ мод хагалах, ус зөөх зэрэг ажил хийлгэдэг гэжээ.

## Эцэг эхийн хандлага

Хүүхдүүдийн хариулснаар тэдний эцэг эхчүүдийн дөрөвний нэг нь хүүхдүүдээ алт олборлоход дуртай байдаг, 41 хувь нь дургүй боловч хорьдоггүй, 11.5 хувь нь юу ч хэлдэггүй, 22 хувь нь ийм ажил хийхийг хориглодог ажээ..

... Ажлын нөхцөл маш хүнд. Би өөрөө толгойноосоо доош шороонд даруулж ч үзсэн. Гэхдээ амьдрахын эрхээр хэдэн хүүхдүүдээ дагуулаад энэ ажилд явж байна. Цалин хөлсөө тогтмол цаг хугацаанд нь өгдөг байгууллага байвал ажилд ормоор байна.

(Б., 45 настай эрэгтэй, Жаргалант)

Алт олборлуулах ажлыг хүүхдүүдээрээ цаашид үргэлжлүүлэн хийлгүүлнэ гэж эцэг эхчүүдийн 42 хувь нь, ажиллуулахгүй гэж 39 хувь нь, түр хугацааар ажиллуулна гэж 16 хувь нь хариулж байна.

Сургуулийн насын сургуульд суралцдаггүй хүүхдээ боломж байвал цаашид суралцуулах хүсэлтэйгээ бараг бүх эцэг эхчүүд илэрхийлжээ.

## Бодлогын зөвлөмж

- Уурхайд хүүхэд ажиллахын эрсдэл, хор уршиг, мөнгөн устай харьцахын хортой нөлөөллийн талаарх эцэг эх, хүүхэд, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх;
- Уурхайд хөдөлмөр эрхэлж буй өрхийн орлогыг нэмэгдүүлэх замаар хүүхдийг аюултай ажлаас хөндийрүүлэх, энэ ажлыг боловсрол, сургалтын арга хэмжээтэй хослуулах;
- Албан бус алт олборлолт буюу эдийн засгийн үйл ажиллагааны үр өгөөжийг орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой зохицтойгоор уялдуулах;
- Албан бус алтны уурхайд мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зөвлөгөө, удирдамжийг боловсруулж, иргэдэд энгийн хялбар арга замуудыг зааж сургах;
- Албан бус олборлолтын аюулгүй ажиллагаа, хүүхэд ажиллуулахгүй байх зэрэг шаардлагад тавих орон нутгийн төр захиргаа ба олон нийтийн хяналтын үр дүнтэй механизмыг бий болгох.

## Алтны уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн байдал

### Судалгаа хийсэн байгууллага:

МУИС-ийн Хүн Амьн Сургалт,  
Судалгааны Төв

### Судалгаа хийсэн он:

2002

### Хамрагдсан газрууд:

Сэлэнгэ аймгийн Баянгол (Баруунхаараа),  
Ерөө, Төв аймгийн Сүмбэр, Жаргалант,  
Дархан уул аймгийн Шарын гол сумд

Энэхүү судалгаанд дээрх сумдаас зорилттойгоор сонгосон 122 өрхийн б-18 насын 122 хүүхэд хамруулсан. Тэд алтны шороон ба үндсэн ордоос алт олборлох ажилд тогтмол оролцдог хүүхдүүд юм.

## Хүүхдүүд хэт бага насласаа эхлэн алт олборлож, энэ ажилдаа татагдаж байна

### Алт олборлогч хүүхдүүдийн нас, хүйсийн бүтэц

Насны бүлэг	Бүгд	Үүнээс эрэгтэй	Эмэгтэй
13 хүртэлх	36.1	34.8	40.0
13-15	26.2	27.2	23.3
16-18	37.7	38.0	36.7
Дун	100.0	75.4	24.6

Алт олборлох ажлыг эрхэлж буй хүүхдүүдийн 62.3% нь 15 ба түүнээс доош наслых байна.

## Хүүхдүүд хүнд хүчир ажлыг олон цагаар хийж байна

Уурхайд хүүхдүүд ус, шороо зөөх, нүх ухах, чулуу бутлах, шороо шигших, үлээх, алт угаах, алт баруулах зэрэгээр ажиллаж байна. Хүүхдүүдийн талаас илүү хувь нь өөрсдийн хийж буй ажлаа хүнд, бэрхшээлтэй гэж, гуравны нэг нь хүндэвтэр гэж тодорхойлж байна. Хүүхдүүдийн нас ахих тусам ажлаа хүнд, бэрхшээлтэй гэж үнэлж буй хүүхдүүдийн тоо нэмэгдэж байна.

Хүүхдүүд өвлийн улиралд дунджаар 4 цаг, зуны улиралд 16-18 наслыхан 10-11 цаг, харин 16-аас доош наслыхан 8-9 цаг ажилладаг байна. Тэд гэмтэж бэртэх, өлсөж ядрах, хүнд дээрэмдүүлэх, хөөгдөх, шороо чулуу нурах зэргийг тэдэнд тохиолддог бэрхшээл гэж хариулж байна.

Алт олборлох ажлыг анх хийж эхэлсэн дундаж нас 12.2 байна.

Хүйсийн бүтцийн хувьд алт олборлож буй хүүхдүүдийн 3/4 нь эрэгтэй хүүхдүүд байна.


Эрэгтэй хүүхдүүд голдуу найз нөхдийн санаачилгаар ажиллаж эхэлсэн байхад охид ихэвчлэн эцэг эхийн нөлөөгөөр хийж эхэлсэн байна.

Нийт хүүхдүүдийн 60 гаруй хувь нь мөнгө олдог учраас алт олборлох ажилдаа дуртай гэжээ. Бага насын хүүхдүүд энэ ажлыг зугаатай гоё хэмээн дуртай байдаг байна.

... Одоо цагаан сар болох гэж байгаа учраас хүмүүс бүр их байна. Өвөл хүүхдүүдээ нүх рүү оруулчихаад хүлээгээд цасан дээр хэвтдэг. Заримдаа суугаагаараа ч хонено. Жижиг хүүхдүүд одтой чулуу их олдог. Амьдрал гайгүй бол хүүхдүүдээ ингэж зовоох хэрэг алга даа.

(Л., 40 настай, эмэгтэй, Баруунхараа)

## Хүүхдүүд мөнгөн усаар алт бариулж байна



Судалгаанд хамрагдсан нийтийн хүүхдүүдийн 37.7 хувь нь мөнгөн усаар алт бариулж байна. Хүүхдийн нас нэмэгдэх тутам эрэгтэй хүүхдүүд мөнгөн ус хэрэглэх явдал өндөр байна. Хүүхдүүдийн 88.9 хувь нь мөнгөн усыг хувь хүмүүс, наиз, танилаасаа авдаг, 6.7 хувь нь өөрсдөө олборлодог, 4.4 хувь хулгайлдаг гэжээ.

Хүүхдүүд мөнгөн усаар алт бариулах ажлыг голдуу (66.7 хувь) гэртээ хийж байна.

... Манай дүү охин 2-3 насны 2 охинтой. Тэр гэртээ мөнгөн усаар алт бариулдаг. Тэр энэ ажлыг сайн хийдэг. Хүн болгон сайн барьж чаддагүй юм. 3000-6000 төгрөгөөр барьдаг. Өөрийнх нь гараар их юм туурдаг. 2 охин нь ч гэсэн маш их тууралттай байдаг...

(А., 35 настай, эмэгтэй, Бугант).

... Одоо манай гэрийнхэн бүгдээрээ мөнгөн усны хордлоготойг эмнэлгээр тогтоолгосон, хүүхдүүдийн маань үс туг тугаараа унаж байна. Эмнэлэгт хэвтэх гэсэн боловч даатгалын дэвтэр авах мөнгөгүй болчихоод байна. Улаанбаатар явж бүр чадахгүй юм.

(Ч., 53 настай, эмэгтэй, Сүмбэр)

## Хүүхдүүд сургууль завсардан эсвэл хичээлийн бус цагаараа алт олборлож байна

Алт олборлож буй хүүхдүүдийн 34.4 хувь нь сургуульд суралцаагүй байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн дийлэнх нь 5-р ангиасаа сургуулиасаа гарсан байна. Бага ангийн хүүхдүүд суралцах бичиг, хувцасны зардал өндөр учраас харин дунд болон ахлах ангийн хүүхдүүд голдуу суралцах сонирхолгүй, сурлага муу, өөрийн орлогод тус нэмэр болох зорилгоор сургуулиас гарчээ.

... Баруун хараад 500 гаруй хүүхэд алтанд явдаг. Хичээлээ таслаад л явдаг. 7-10 дугаар ангийнхан бүтэн, хагас өдөр явна. Манай эндхийн 14-15 насны хүүхдүүдийн дийлэнх нь явдаг. Жижгүүд бол зун их явдаг.

(Л., 40 настай, эмэгтэй, Баруунхараа)

Сургуульд суралцахын зэрэгцээ хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 26.3 хувь нь бага, 63.8 хувь нь дунд, 10 хувь нь ахлах ангийнхан байна.

Сургууль завсардсан хүүхдүүдийн 83.3 хувь нь боломж олдвол цаашид суралцах хүсэлтэй гэж хариулсан байна. Гэхдээ сургуульд суралцах сонирхолтой гэж хариулсан хүүхдийн хувь 13-15 насныханд хамгийн бага байна.

## Хүүхдүүдийн олсон орлого ба өрхийн амьжиргаа

Хүүхдүүдийн тавны нэг орчим нь өөрсдийнх нь олсон орлого өрхийн орлогынх нь эх үүсвэр гэж хариулжээ. Харин тэдний 43.4 хувь нь өрхийн орлогод боломжийн хэрээр, 33 хувь нь бага нэмэр болдог гэж дүгнэж байна. Өөрийн олсон орлогыг өрхийнхөө орлогын гол эх үүсвэр гэж үзэж буй эрэгтэй хүүхдүүдийн хувь охидынхоос 3 дахин өндөр байна.

## Хүүхдүүд эрүүл мэндэд нь аюултай хөдөлмөр эрхэлж, эмнэлгийн тусlamж авахгүй байна

Хүүхдүүдийн 22.5 хувь нь осолд орж байсан ба давхардсан тоогоор 92.6 хувь нь хөл гар, нуруугаа, 14.8 хувь нь тархи толгойгоо гэмтээж байжээ. Гэмтэж бэртсэн хүүхдийн ердөө дөрөвний нэг нь л эмнэлэгт хандсан байна.

Хүүхдүүдийн 50 орчим хувь нь алт олборлох үедээ ямар нэг өвчин тусч байжээ. Тэд гол төлөв амьсгалын замын өвчин ханиад хатгалгаа авсан, үе мөч нурууны өвчин тусч байжээ.

... Надтай хамт алтанд явдаг 15 настай хүү 4-5 жил энэ ажлыг хийж байгаа. Тэр маш жижиг биетэй. Хүнд шороо үүрч, хүнд ажил хийсээр байгаад өсөлт нь зогсчихов уу гэж боддог....

(Э. эмэгтэй, 14 настай, Бугант)

Эцэг, эхчүүд алт олборлох ажлыг хүнд, тэр тусмаа хүүхдэд бүр аюултай гэдгийг бүгд хүлээн зөвшөөрч байна. Тэднээс алт олборлох ажил танай хүүхдүүдийн чинь эрүүл мэндэд ямар сөрөг нөлөөлөл үзүүлсэн тухай асуухад давхардсан тоогоор

- 43.3 хувь нь амьсгалын замын өвчин байнга тусдаг,
- 41.7 хувь нь бөөр шээсний замын өвчтэй,
- 25.0 хувь нь үе мөч нурууны өвчтэй,
- 23.3 хувь нь нүдний хараа, чих хамар хоолой муу,
- 20.0 хувь нь механик гэмтэл авсан,
- 10.0 хувь нь зүрх муудаж, ядаргаатай болсон,
- 3.3 хувь нь биеэр юм туурч, үс нь унах тохиолдол гарсан гэжээ.

... Хүүхдүүд алт ухсанаас болж бөөрний өвчтэй болдог. Гар дээгүүр нь юм гарч, гарны арьс нь хагардаг. Хүүхдүүд шорооон дээр ажиллаж байхдаа даруулж бэртэх тохиолдол маш их байдаг. Үнээс болж өнгөрсөн жилд 2 хүүхэд нас барсныг сонссон....

(Ц., 38 настай, эмэгтэй, Шарын гол)

## Айлд ажиллаж буй хүүхдүүд хөгжлөөс хоцрогдож, ганцаардмал байдалд байна гэж хариулж байна

Айлын мал маллаж буй хүүхдүүдийн 24 хувь нь айлынхаа хажууд тусдаа гэрт эсвэл бие дааж тусдаа амьдардаг, 54 хувь нь ажиллуулж байгаа айлдаа амьдардаг байна. Хүүхдүүдийн дөрөвний нэг шахам хувь нь айлд байхад тохьгүй, отор нүүдлийн үед маш хүйтэн нөхцөлд дан бүрээстэй гэрт л амьдардаг гэжээ.

Айлд мал малласнаар хүүхдүүд гэр бүлдээ тус нэмэр болж, хоол хүнтэй байгаа хэдий ч сурч боловсрох боломж нь

хязгаарлагдсан, соёлоос хоцорсон, олон хүнтэй харьцаж чаддаггүй, ганцаардмал болсон гэж өгүүлж байна. Айх тохиролцсоноосоо илүү их ажил хийлгэдэг, ажиллуулагч айлын эзэдтэй зөрчилдөөнтэй байдаг зэргийг хамаатан биш айлд ажиллаж буй хүүхдүүд голдуу өгүүлж байв. Түүнчлэн гэр орноосоо хол айлд ажиллаж буй хүүхдүүдийн 26.5 хувь нь гэр орныхонтойгоо хааяа уулздаг, учир нь ажил хийлгүүлж байгаа айл нь хүн бүл муутай учир зав гардаггүй гэж байв.

## Мал маллаж буй хүүхдийн талаарх хөдөөгийн иргэдийн үзэл бодол

Асуулгад оролцсон өрхийн 72.5 хувь нь мал маллах нь хүүхдэд өөрт нь тустай, харин хүүхдийн насыны онцлог, бие чадварт нь тохирсон, хөдөлмөр хамгааллын аюулгүй нөхцлийг хангасан байх нь чухал гэж үзэж байна. Гэвч насандаа хүрэгсэд өөрсдийнхөө бага нас, хөдөөгийн амьжиргааны уламжлалт хэв маягаар “Бид ч гэсэн тэгж л өссөн, тэгээд муудсан юм алга байна” гэсэн хандлага давамгайлж байлаа.

## Өвлийн морин уралдааны талаарх орон нутгийн хүмүүсийн үзэл бодол

Малчид, малчин хүүхдүүд, орон нутгийн хүмүүс өвлийн морин уралдаан нь хүүхдийн эрүүл мэндэд үнэхээр халтай, ханиад томуу хүрэхээс хатгаа авах гээд хүндрэл их гардаг, мориноос хүүхэд ойчиход хөлдүү газар ямар ч гэмтэл авч болно гэж үзэж байна. Өвлийн уралдаанд морь унаж байсан хүүхэд тайлбарлахдаа “... хацар ам хөлдөх бол юу ч биш, их хурдтай явснаас нүднээс нулимын гарч, сормуус хөлдөөд нүдээ ч нээж чадахаа байдаг, хацар нүүр ам хөлдөөд ямар ч мэдээгүй болдог” гэж байлаа.

### Бодлогын зөвлөмж

- Цаашид хүүхдийн хөлсний хөдөлмөрийг мал аж ахуйд ашиглах явдал өсөх чиг хандлагатай тул хөдөө аж ахуй дахь хөлсний ажлын талаарх хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Сургууль завсардсан, нэн ялангуяа амьдралын боломжгүйгээс завсардсан хүүхдүүдэд зориулсан боловсрол нөхөн олгох сургалтуудыг нэмэгдүүлж, бага насыны хүүхдүүдийг ЕБС-д эргүүлэн сургах, ахлах насыны хүүхдүүдийг дүйцэн хөтөлбөрийн сургалтаар сургах;
- Айлд мал маллах нь бага насыны хүүхдэд хэр тохиромжтой эсэхийг хэлэлцэх;
- Мал аж ахуй дахь насандаа хүрээгүй хүүхдэд аюултай ажлын нөхцлүүдийг тодорхойлох;
- Айлд ажиллаж буй хүүхдүүдийн байдал, тэдний эрхийн хангалтын байдалд орон нутгийн засаг захирагааны байгууллагууд анхаарлаа хандуулдаг байх;
- Өвлийн морин уралдаанд бага насыны хүүхэд оролцуулахыг хориглох, өвлийн уралдааны үед өмсөх хамгаалалтын хувцас, хэрэгслүүдийг тодорхойлж, мөрдүүлэх.

## Айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн байдал

Судалгаа хийсэн байгууллага:

Нийгмийн Хөгжлийн Төвийн Зөвлөх Нэгж

Судалгаа хийсэн он:

2001

Хамрагдсан газрууд :

Өвөрхангай, Ховд аймгийн 12 сум


Сүүлийн жилүүдэд хамран сургалтын түвшин дээшилж байгаа хэдий ч сургууль завсардсан хүүхдүүдийн асуудал анхаарал татсан хэвээр байна. Өрхийн ядуурал, мал маллах хүн хүчгүй зэрэг шалтгаанаар хөдөөд олон хүүхэд сургуульд огт ордоггүй эсвэл завсардсан хэвээр байна. Хөдөөд сургууль завсардсан хүүхдүүдийн ихэнх нь өрхийн аж ахуйд ажилладаг хэдий ч бусад айлд хөлслөгдхөн явдал бий болоод байгаад анхаарлаа хандуулж айлд мал маллаж буй хүүхдүүдийн нөхцөл байдал, тэдний хийж буй хөдөлмөр хүнд, мөлжлөгийн шинжтэй байгаа эсэхийг тодруулах зорилгоор судалгааг дээрх аймгуудын 12 сумын 255 малчин өрх (үүнээс бусдын хүүхэд ажиллуулж буй 122 өрх) 291 малчин хүүхдийн (үүнээс айлд ажиллаж буй 132) дунд явуулав.

### Хөдөөгийн хүүхдүүдийн дийлэнх нь амьдралын гачигдлаас болж сургууль завсардаж байна

Судалгаанд хамрагдсан, мал дээр ажиллаж буй хүүхдүүдийн 72.8 хувь нь сургууль завсардсан эсвэл огт сургуульд суугаагүй хүүхдүүд байна. Тэдний 87.6 хувь нь өөрийн сонирхлоороо бус амьдралын гачигдлаас, ах дүүстээ туслах, өөрийн малаа маллах зэрэг шалтгааны улмаас мал маллах болжээ. Эдгээр хүүхдүүдийн 45 хувь нь цаашид суралцах сонирхолтой байгаа бөгөөд 9-12 насыны хүүхдүүд сургуульд суралцах, харин 13-16 насыны хүүхдүүд голдуу явуулын багшийн тусламжтайгаар, эсвэл зайнны сургалтаар болон бие дааж суралцах сонирхолтой ажээ.

### Айлд ажиллаж буй хүүхдүүд голдуу 13-15 насыны, эрэгтэй хүүхдүүд байна

Айлд ажиллаж буй хүүхдүүдийн нас, хүйс



Айлд мал маллаж байгаа, эсвэл гэрийн үйлчилгээний ажил хийж буй хүүхдүүдийн 76.5 хувь нь эрэгтэй, 23.5 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Эдгээр хүүхдүүдийн ихэнх нь 13-15 насыны эрэгтэй хүүхдүүд байна. Гэвч бага насыны хүүхдийн эзлэх хувь нилээд өндөр, ялангуяа эмэгтэй хүүхдийн эзлэх хувь бусад насыны бүлгүүдээс өндөр байгаа нь анхаарал татлаа.

## Өрхийн ядуурал, олон мал бүхий өрхөд хүн хүч дутагддаг нь хүүхдүүд айлд ажиллах гол шалтгаан болдог

Хүүхдүүд айлд мал мallaх болсон шалтгаан

	Шалтгаан	Хувь
1	Амьдралын боломжгүйгээс	50.0
2	Өөрийн сонирхол	3.8
3	Өөрийн малгүй	3.8
4	Тухайн айл хүн хүчгүй	40.9
5	Өнчин	1.5
<b>Нийт</b>		<b>100.0</b>

Хүүхдээ айлд ажиллуулж буй өрхийн 26.0 хувь нь огт малгүй, 42.0 хувь нь 50 хүртэл толгой малтай 32.0 хувь нь 51-100 толгой малтай байна. Эдгээр өрхийн 35.0 хувь нь бусадаас өртэй, ихэнхдээ хавар цагаан сар, намар хичээл эхлэх үеэр бусдаас зээлээд ноолуур,

мах бэлтгэлийн үеэр өрөө эргүүлэн төлдөг байна. Гэвч тэдний гуравны нэг шахам хувь нь өрөө хэрхэн эргүүлэн төлөхөө мэдэхгүй буюу төлөх боломжгүй гэж хариулжээ.


Нөгөө талаас, хүүхэд ажиллуулж буй өрх голдуу цөөн ам бүлтэй, өндөр настан, бага насны хүүхдэтий, хүүхдүүд нь сургуульд сурдаг, эсвэл хүүхдүүд нь тусдаа айл болсон айлууд байна. Эдгээр өрхийн 57 хувь нь 201-500 толгой малтай, 3.3 хувь нь 500-гаас дээш, үлдсэн 39 хувь нь 200 хүртэл толгой малтай байв.

“Жишээ: Ховд аймгийн Мөст сумын малчин Д-гийн өөрийн малгүй ядуу амьдралтай өрх бөгөөд эдний 5 хүүхэд (12-18 насны) нь бүгд сургууль завсардсан. Эднийх айлын 200 орчим малыг хөлсөөр маллаж байна. Эцэг эх нь “манай хүүхдүүд бүх ажлыг эцэг эхийн оролцоогүй хийж чаддаг, санаа зовох явдал байдаггүй” гэж ярьж байна. Хөдөлмөрийн хөлсөнд сард 2 шуудай гурил авдаг”

Айлд ажиллаж буй хүүхдүүдийн талаас илүү хувь нь сургууль завсардсан эсвэл огт сургуульд орж байгаагүй хүүхдүүд бөгөөд тэдний эцэг эх нь санхүүгийн бэрхшээл, байр унааны зардал өндөр, хичээлийн хэрэгсэл авч өгч дийлдэггүй гэж хариулж байна.

## Хүүхдүүд бага хөлсөөр, голдуу аман гэрээгээр ажиллаж байна

Айлд ажиллаж буй хүүхдүүдийн хийдэг ажлууд



Хүүхдүүдийн 77 хувь нь эцэг эх болон ажил олгогч санал болгосны улмаас айлд ажиллах болсон гэжээ. Хамаатнаасаа өөр айлд ажиллаж буй хүүхдүүд аман тохиролцооны дагуу ажилладаг бөгөөд тэдний ажлын хөлсийг гол төлөв

ажиллуулагч тодорхойлдог байна. Айлд ажиллаж буй хүүхдүүд гол төлөв мал мallaадаг, улирлын чанартай ажил хийдэг байна. Мөн мал мallaахын зэрэгцээ гэр орны ажил хийдэг, эсвэл зөвхөн гэрийн үйлчилгээний ажил хийж байна.

Ажлын хөлсийг ихэвчлэн (81 хувь) ар гэрт нь гурил будаа, өвлүүн идэш, мал өгөх, хүүхдийн өөрийнх нь хоол хүнс, хувцас, хичээлийн хэрэглэлийг нь бэлтгэж өгөх зэрэг биет хэлбэрээр олгож байна. Ажлын хөлсөө мөнгөөр авдаг хүүхдүүдийн ажлын хөлсний дундаж хэмжээ нь сард 9071 төгрөг байгаа нь хөдөлмөрийн хөлсний (тухайн үеийн) доод хэмжээнээс 2 дахин бага байна. Хүүхдүүдийн ажлын хөлс нь тэдний ажлын цаг, ажлын төрөл, ачаалалтай огт уялддаггүй ажээ.

## Айлд ажиллаж байгаа хүүхдүүд ажлын нөхцлөө хэрхэн үнэлж байна вэ?

Хүүхдүүдийн 50 хувь нь хоногт 8-10 цагаар ажиллаж зарим тохиолдолд томчуудын хийдэг ажлыг яг ижил нөхцөлд хийж байна. Амьдралын аргагүй шаардлагаар өөр айлд мал мallaаж байгаа 10-13 насны хүүхдүүд ажлаа өөрсдийнх нь нас биед тохиорогүй гэж илүүтэй хариулж байв.

Байнга хийдэг ажлуудаас хамгийн хүнд байдаг ажлуудыг хүүхдүүдээр тодорхойлуулахад мал төллүүлэх, алдсан мал хайхыг тус тус хамгийн олон удаа нэрлэж байв. Хаврын цагт өдөр шөнөгүй төл хүлээн авах, амлуулах, тэжээх зэрэг олон ажлыг хүн хүчиний хүрэлцээ муу байхад хийдэг, өвөл, зуны аль ч цагт алдсан мал хайх нь тогтоосон цаг, хугацаагүй үргэлжилдэг, заримдаа 3-4 өдрөөр мал хайж, 50-200 км мориор явах, таньж мэдэхгүй айлд хоноглох, хоол ундгүй удаан явдаг тул хүнд ажил гэж хүүхдүүд үзэж байна.

Түүнээс гадна хашаа хороо, өтөг бууц цэвэрлэх, аргал түүх, мод, өвс хадлан бэлтгэх, отор, мал туварт явахыг мөн нэрлэж байна. Ялангуяа өвлийн улиралд оторт

явахад хоол хүнс муу, отрын гэр тохь муутай хүйтэн, түлээ түлш олдохгүй, ер нь л малтайгаа ижил нөхцөлд л өдөр хоногийг өнгөрөөдөг нь үнэхээр хүндрэлтэй байдаг ба цөөхөн мал ч байсан ялгаагүй гэж байв. Хүүхдүүд ихэнх тохиолдолд ажил олгогчийн хамт отор хийдэг боловч заримдаа ганцаараа бие даан оторт явах тохиолдол гардаг байна.

Оторт явахдаа таньж мэдэхгүй газар хүн бүл муутай явдаг учир араатан амьтан, нутгийн хүмүүсээс ч аиж байдаг. Бэлчээр нутгийн маргаан байнга гарч айлан сүрдүүлэх, хөөх зэрэг байнгын дарамтад байдаг учир хүнд хөдөлмөр гэж тодорхойлж байна. Мал тууварт явахад олон хоног гэррээсээ хол, хоол унд муутай, цаг агаарын хүнд нөхцөлд, байнга малаа даган нүүдэллэж байдаг учраас хүнд байдаг гэж тайлбарласан байна.

Түүнчлэн гар аргаар мал угаах, туулгарт хийх, өвөл хурдны морь унах зэргийг хүүхдийн хувьд хүнд хөдөлмөр гэж үзэж байв.

## Хөдөөгийн ядуу өрхийн хүүхдүүд өөр айлд ажиллах явдал нэмэгдэх хандлагатай байна

Хүүхдүүдийн 30 хувь нь 1 жилийн өмнөөс, 23 хувь нь 2 жилийн өмнөөс, 20 хувь нь 3 жилийн өмнөөс, 27 хувь нь 4-6 жилийн өмнөөс айлд мал мallaаж эхэлсэн гэжээ. Үүнээс харахад амьдрал ядуу өрхүүд хүүхдүүдээ өөр айлд хөлсөөр мал мallaулах явдал цаашид өсөх хандлагатай байна.

## Хүүхдүүд өвдсөн, гэмтсэнийг эцэг эх, ажиллуулагч нар тэр бүр мэддэггүй байна

Айлд ажиллаж буй хүүхдийн өвчлөл, осол

	Хүүхэд	Эцэг Эх	Ажиллуулагч
Тийм	17.4	2.3	3.0
Үгүй	73.5	43.9	51.5
Хариулаагүй	9.1	53.8	45.5
	100.0	100.0	100.0

Хүүхдүүд айлд ажиллаж байх явцдаа ямар нэгэн өвчин туссан, гэмтэж бэртэж байсныг асуухад тийм гэж хариулсан хүүхдүүдийн хариулт эцэг эх, ажиллуулагч өрхийн хариултаас хол зөрж байгаа нь хүүхдүүд өвдөж, гэмтэж бэртсэнийг эцэг, эх, ажиллуулагч нар тэр бүр мэддэггүйг харуулж байна. Хүүхдүүд мориноос унаж хөл гарсаа хугалах, моринд өшиглүүлэх, эмнэг сургаж байгаад гэмтэх, чих хацраа хөлдөөх зэрэгт илүүтэй өртдөг байна. Ийм төрлийн гэмтлүүдээс шалтгаалан толгой байнга өвдөг болох, эрхтний хэвийн ажиллагаа алдагдах, улмаар тахир дутуу болох хожмын сөрөг нөлөө ихтэй юм.

Хүүхдүүд айлд ажиллаж байх явцдаа ямар нэгэн өвчин туссан, гэмтэж бэртэж байсныг асуухад тийм гэж хариулсан хүүхдүүдийн хариулт эцэг эх, ажиллуулагч өрхийн хариултаас хол зөрж байгаа нь хүүхдүүд өвдөж, гэмтэж бэртсэнийг эцэг, эх, ажиллуулагч нар тэр бүр мэддэггүйг харуулж байна. Хүүхдүүд мориноос унаж хөл гарсаа хугалах, моринд өшиглүүлэх, эмнэг сургаж байгаад гэмтэх, чих хацраа хөлдөөх зэрэгт илүүтэй өртдөг байна. Ийм төрлийн гэмтлүүдээс шалтгаалан толгой байнга өвдөг болох, эрхтний хэвийн ажиллагаа алдагдах, улмаар тахир дутуу болох хожмын сөрөг нөлөө ихтэй юм.

Асуулгад хариулагчдын 32.0% нь мөнгөн усаар алт баруулах үедээ ямар нэгэн хамгаалах хэрэгсэл хэрэглэдэг гэсэн бөгөөд голдуу амны хаалт, бээлий хэрэглэж байна. Амны хаалт нь амьсалаар мөнгөн ус нэвчихээс бүрэн хамгаалах боломжгүй тул хүмүүсийн хэрэглэж байгаа энэ арга нь үр дүн багатай юм. **Хүүхдүүдийн 95.0 хувь нь ажлын хувцас хамгаалах хэрэгсэл хэрэглэдэггүй**, 5 хувь нь л хааяа олдвол гарын бээлий хэрэглэдэг гэж хариулжээ.

### Хүүхдүүд хэрээс хэтэрсэн хүнд ачаа зөөж, аюултай нөхцөлд ажиллаж байна

Эрэгтэй хүүхдийн гараар өргөх ачааны зөвшөөрөгдөх дээд хэмжээ 8-16 кг, эмэгтэй хүүхдүүдийн хэмжээ 5-10 кг байдаг. Хүүхдүүд уурхайд төрөл бүрийн ажил хийдгийн дотор шороо, чулуу өргөх, зөөх ажлыг нилээд хийж байна. **Эрэгтэй хүүхдүүд хагас шуудай буюу ойролцоогоор 25-40 кг зарим тохиолдолд 50-60 кг жинтэй шуудай дүүрэн шороо, чулууг 5-10 метр орчим зайд өргөж, зөөх ажлыг хийж байна.**

Хүүхдүүд тээрмийн машин дээр болон гараар том чулуу хагалж, бутлах, жижиглэх ажилд оролцож байна. Энэ нь тэдний хувьд нэлээд хүнд хэцүү, бас аюултай ажил юм. Тоос их гарч байна. Амны хаалт, хамгаалалт байхгүй байна. Том алх лантуугаар (10-20 кг-ийн) чулууг бутлахад чулуу үсрэх, гар хөлөө цохиж, гэмтээж болзошгүй байна. Уурхайн гүн рүү ороход нурангид дарагдах, агааргүйдэх, осол гэмтэлд орох эрсдэлтэй ажиллаж байна.

Чулуу бутлагч тээрмүүд тоос, дуу шуугиан их гаргадаг бөгөөд гар аргаар хийгдсэн, хаалт хамгаалалт байхгүй байна. Хутган бутлагч тээрмүүд нь задгай байрлагдсан, цахилгааны холболт, монтаж нь шаардлага хангахгүй байдалтай ажил үйлчилгээ гүйцэтгэж байна.

### Бодлогын зөвлөмж

- Мөнгөн усны хортой нөлөөллийн талаарх уурхайчид, орон нутгийнхний ойлголтыг дээшлүүлэх;
- Завсрын арга хэмжээ болгон мөнгөн усаар хүний биед болон байгаль орчинд хоргуй технологийг уурхайчдад зааж сургах;
- Уурхай дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаарх уурхайчдын мэдлэгийг дээшлүүлэх;
- Хүүхдээр мөнгөн усаар алт баруулдаг практикийг таслан зогсоох, үүний тулд орон нутгийнхний эрүүл мэнд болон засаг захиргааны хяналтыг дээшлүүлэх;
- Алтны уурхайд хүнд хөдөлмөр эрхэлдэг өрхүүдийн орлогыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч хүүхдийг аюултай хөдөлмөрөөс хөндийрүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг (эрүүл мэндийг нь нөхөн сэргээх, сургууль, мэргэжлийн сургалтад хамруулах зэрэг) цогцоор нь хэрэгжүүлэх.

## Хувиараа алт олборлогчдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын байдал

Судалгаа хийсэн байгууллага:

Эрүүл Мэндийн Яалны харьяа  
Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Судалгаа хийсэн он:

2002

Хамрагдсан газрууд:

Сэлэнгэ, Төв, Дархан уул аймгийн 6 сум


Энэхүү судалгааг мөнгөн усаар баруулах аргаар алт олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, уурхайд албан бус хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны байдалд дүгнэлт хийх, ажлын байран дахь мөнгөн усны агууламжийг тодорхойлох, хүний эрүүл мэндэд мөнгөн усны үзүүлэх хортой нөлөөллийн талаархи хувиараа алт олборлогчдын мэдлэг, дадал, хандлагыг үнэлэх зорилгоор дээрх сумдад хувиараа алт олборлож буй 132 хүүхэд, 209 насанд хүрэгсдийг хамруулан явуулав.

### Үндсэн ордоос алт олборлож буй иргэд мөнгөн усаар алт баруулж, гэртээ голдуу хэрэглэж байна

Мөнгөн ус хүний үс, хумс, цусанд хуримтлагдахаас гадна цусаар дамжин элэг, бөөр, дэлүү, уураг тархийг гэмтээдэг. Бие махбодоос шээс, хөхний сүүгээр ялгардаг. Хүмүүс мөнгөн усны бага тунгаар удаан хугацаанд алт баруулах явцад агаарт ууршсан мөнгөн усаар амьсгалан энэ үйлдэл олон удаа давтагдаад аажмаар архаг хордлогод ордог. Ингэхдээ хүний мэдрэлийн тогтолцог хамгийн түрүүнд сонгомлоор гэмтээж эмчилгээ авахааргүй эргэшгүй өөрчлөлтөд оруулж насан туршийн мэдрэлийн согог буюу **хордлогын гаралтай Паркинсоны өвчин** үүсгэдгээрээ нэн аюултай.

Судалгаа анд хамрагдагсдын ихэнх нь буюу **67.9 хувь нь мөнгөн усаар алт баруулж**, ууршуулан хэрэглэж байна. Үүнээс хүүхдүүдийн 32.8 хувь, насанд хүрэгсдийн 82.0 хувь нь мөнгөн усаар алт баруулж байна.

**Уурхайчдын 63.0 хувь мөнгөн усаар алт баруулах ажиллагааг гэртээ хийдэг**. Энэ үед гол



## Мөнгөн усаар алт бариулж буй арга

Арга	Хүүхэд	Насанд хүрэгчид	Бүгд
Гар дээрээ	52	79	72
Түмпэнд	19.2	11.6	13.5
Шприцэнд	7.7	4.7	5.5
Халбаганд	17.3	1.3	5.5
Даавуунд	3.8	3.4	3.5
<b>Бүгд</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>

төлөв гэр бүлийн бусад гишүүд хамтдаа байдаг ажээ. Нийт уурхайчид, хүүхдүүдийн 72 хувь нь алтыг мөнгөн усаар гар дээрээ бариулдаг байна. Мөнгөн усыг халбага дээр тавьж ууршуулдаг хүүхдийн тоо насанд хүрэгсдийнхээс **13.3 дахин их** байна.

## Хувиараа алт олборлож буй иргэд, хүүхдүүдэд мөнгөн усны архаг хордлого илрэв


Нийт судалгаанд оролцогдын 17 хувь буюу 59 хүнд мөнгөн усны архаг хордлогын эмнэл зүйн буюу клиникийн шинж тэмдэг илэрсэн. Эдгээр 59 хүний 17 нь хүүхэд байсны **48 хувьд нь мөнгөн усны архаг хордлогын** шинж тэмдэг

л а б о р а т о р и й н хүүхдийн 24.2%, насанд хүрэгчдийн 13.3%-д мөнгөн усны хордлогын шинж тэмдэг илрэв.

Асуултад хариулсан 231 хүний 16.5% -д нь мөнгөн устай ажиллаж эхэлснээс хойш эрүүл мэндийн байдалд нь өөрчлөлт гарсан, үүнээс асуулгад хамрагдсан 66

хүүхдийн 24.2%, насанд хүрэгчдийн 13.3%-д мөнгөн усны хордлогын шинж тэмдэг илрэв. Энэ нь мөнгөн усны хортой нөлөөлөлд хүүхдүүд насанд хүрэгчдээс **1.8 дахин илүү** өртөж байгааг харуулж байна.

Мөнгөн усны хурц хордлогын шинж тэмдэг судалгааны явцад төдийлэн илрээгүй бөгөөд энэ нь мөнгөн усыг бага тунгаар удаан хугацаанд хэрэглэж байгаатай холбоотой байж болзошгүй юм. Мөнгөн ус хэрэглэснээс үүссэн байж



болзошгүй бие загатнах туурах, үе мөч өвдөх зэрэг шинжүүд уурхайчдад илэрч байгаа бөгөөд эрүүл мэндэд нь өөрчлөлт гарсан хүмүүсийн 64.5 хувь нь

эмнэлэгт хандаагүй, 29.0 хувь нь мөнгөн устай харьцаахаа болихоор гайгүй болдог, 6.5 хувь нь харшлын эсрэг өвчин намдаах эм уудаг гэж хариулжээ.

## Ажлын байран дахь мөнгөн усны агууламж эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж байна

Хувиараа алт олборлож гэртээ, гаднаа зуухан дотроо мөнгөн усыг ууршуулж байгаа 4 айлын зуухны яндангаар ялгарч буй мөнгөн усны уурыг шингээн авч тухайн орчны агаар дахь мөнгөн усны

хэмжээг тодорхойлоход зөвшөөрөгдөх хэмжээнээс **5-12 дахин ихэссэн** байна. Хэдийгээр энэ нь 11 минут орчим үргэлжилж байсан ч олон удаа давтагдаа тул хүний эрүүл мэндийг муутгахад хангалттай нөлөө үзүүлнэ.

## Хэрэглэсэн мөнгөн усны хаягдал байгаль орчинд халтай тухай ойлголт хангалтгүй байна

Мөнгөн ус хэрэглэгчдийн 69 хувь нь алт бариулсан мөнгөн усны үлдэгдэлтэй бохир усыг хашаандаа, жорлонд, муу усны цоонготоо, хaa сайгүй асгадаг байна. Мөн мөнгөн усаар алт бариулах ажлыг голын орчимд хийж байна.


Эндээс орчны ус, хөрс бохирдож эргээд мал, загасны махаар дамжин мөнгөн усны илүү хортой нэгдэл болох органик мөнгөн усны хордлогод орох орчны эрсдэлт нөхцөл бүрдэж байна.

## Мөнгөн усыг олж авдаг сурвалжууд

Мөнгөн усыг ихэнх уурхайчид алт худалдаж авдаг хүмүүс болон ТҮЦ-нээс худалдаж авдаг, цөөн хэсэг нь Бороо голын орчмоос түүх, айлаас дамжуулан авч хэрэглэдэг байна.

## Хувиараа алт олборлогчдын дийлэнх нь мөнгөн усны хорын талаар мэдэхгүй байна

Мөнгөн усны хортой нөлөөний талаарх мэдлэгийн (оловсролын түвшнээр)



Судалгаанд хамрагдагсдын **69.4 хувь нь мөнгөн усны хортой нөлөөллийн талаар огт мэдэхгүй байна.**

Мэдэхгүй гэж хариулагсдын дийлэнх нь бага буюу бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Мөнгөн усны хортой нөлөөллөөс хамгаалах аргын талаар мэдэхгүй гэж судалгаанд хамрагдагсдын 79 хувь нь хариулж байна. Хүүхдүүдийн 92.0 хувь нь мөнгөн усны хорын талаар огт мэдэхгүй ажээ.

## Хувиараа алт олборлогчид хөдөлмөр хамгааллын талаар мэдлэггүй байна

Хувиараа алт олборлож буй хүмүүс давчуу, хязгаарлагдмал орчинд удаан хугацаагаар биеийн албадмал байдалд ажилладаг. Ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын шаардлагыг мөрддөггүй, мэдэх ч үгүй байна. Газрын гүнд, нүх, хонгил, агууд ажиллах үед бэхэлгээ, хамгаалалт хийж ажиллах ёстой. Гэтэл зөвхөн нүхний амны хэсэгт модоор тулгуур, хавцал хадны дунд ажиллахдаа хөндлөн тулгуур бэхэлгээ хийж байгаа нь бэхэлгээ, хамгаалалтын шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна. Мөн гадагш гаргаж овоолсон шороо, чулуулаг хэсгүүд нь эргэж нуран, хүмүүст осол гэмтэл учруулах нөхцөлтэй байна.

Уурхайд бээлийнээс өөр хамгаалах хувцас, хэрэглэлгүй ажиллаж байна. Сүүлийн 2 жилийн байдлаас авч үзэхэд хувиараа алт олборлогчдоос осолд орж, гэмтэж бэртсэн, эрүүл мэндээр хохирсон тохиолдлууд буурахгүй байна.

## Хүүхдүүдийг хямд ажиллах хүч болгон ашиглах сэтгэлгээ оршиж байна

**Чи хүүхэд** учраас ийм хөлс авах ёстой гэсэн үзэл их байдаг ажээ. Ачаа зөөлөө гэхэд л ачааны жингээс үл хамааран нэг л ижил хөлс өгдөг байна. Ялангуяа 13 хүртэл насын хүүхдүүд тоо мэдэхгүйн дээр маш бага хөлс авдаг ажээ.

... Аймаар их ажил хийчихээд байхад бага мөнгө авдаг нь их хэцүү. Би нэг удаа чиргүүлтэй машин банзыг өдөржингөө буулгаад 1500 төгрөг авсан...

(О. 14 настай, эрэгтэй, Хангай зах)

Хүүхдүүдийн ярьж байгаагаар ажил гүйцэтгүүлэгч голдуу томчуудын авах ёстой хөлснөөс хэд дахин бага хөлсөөр ажиллуулдаг, заримдаа амласан хөлсөө бүрэн өгдөггүй, тохирсон ажлаа дуусгаагүй байхад ажлыг үргэлжлүүлж хийлгэхийг зогсоож, том хүмүүсийг ажиллуулаад, ажлаа дуусгаагүй гэж хэлээд хөлс, мөнгө олгодоггүй тохиолдол нэлээд гардаг байна.

## Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдэд захын захиргаа, дүүргийн зүгээс үзүүлж буй дэмжлэг

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 5 хувь нь захын удирдлагаас, 10 хувь нь дүүргээс хувцас, хичээлийн хэрэглэл зэрэг дэмжлэг авчээ. Дүүргүүдэд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн талаар ямар арга хэмжээ авах, түүнийг ямар журам, механизмаар шийдвэрлэх талаар нэгдсэн ойлголт сул, иймээс тэдэнд зориулан явагдаж буй үйл ажиллагаа хязгаарлагдмал, жигд бус, мэргэжлийн нэгдсэн удирдлага, уялдаа муутай байна.

## Хүүхдүүдийн хүсэл эрмэлзэл

Хүүхдүүдийн 54 хувь нь одоогийн хийж буй ажлаа цаашид үргэлжлүүлэн хийнэ, 40.3 хувь нь хийх сонирхолгүй, 5.7 хувь нь яахаа мэдэхгүй байна гэжээ. Цаашид ажлаа хийх сонирхолгүй хүүхдүүдийн 52 хувь нь сургуульд сурхыг хүсч байгаа бөгөөд ийм хариулт хөвгүүдийн хувьд охидынхаос доогуур байна. Хүүхдүүд үнэгүй эсвэл хямдхан спортын секц, бусад дамжаа хичээллүүлж өгөөч, ялангуяа эрэгтэй хүүхдүүд **бөхийн секц** ажиллуулж өгөөч гэсэн хүсэлт их тавьж байна. Нийт хүүхдүүдийн 29 хувь нь жолооч, 14.3 хувь нь эмч, 13.0 хувь нь багш болохыг хүсдэг гэжээ.

### Бодлогын зөвлөмж

- Иргэд, олон нийт, ялангуяа хүүхдүүдийн дунд хүүхдийн хөдөлмөрийн талаарх ойлголт өгөх, мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;
- Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд захын цагдаа, байцаагч нарын хандаж буй хандлагыг хүүхдэд зөвлөгөө өгдөг, тэднийг дарамт, хүчирхийллээс хамгаалдаг тал руу хандуулах, улмаар зах дээр нийгмийн ажилтныг тодорхой хугацаагаар ажиллуулах;
- Шилжин ирсэн өрхийн хүүхдүүд сургуульд хамрагдахад тохиолдож буй саадыг арилгах, ядуу гэр бүлийн суралцаж байгаа хүүхдүүдэд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх;
- Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн боловсрол, сургалт, эрүүл мэнд, өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг дүүрэг, хороо, сургуулийн нийгмийн ажилтнууд, хөдөлмөр эрхлэлтийн алба, хорооны засаг дарга, захын удирдлагын хамтын ажиллагаа, уялдаатайгаар шийдвэрлэх.

## Зах дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн нөхцөл байдал

**Судалгаа хийсэн байгууллага:**

МУИС-ийн Хүн Ам Зүйн Сургалт,  
Судалгааны Төв

**Судалгаа хийсэн он:**

2002 он

**Хамрагдсан газрууд :**

Улаанбаатар хотын хүнс, барак, түлээ нүүрс, техник, арьс шифний 11 зах

Зах дээр хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн шинж байдал, тэдний ажлын төрөл, ажлын цаг, эрсдэлтэй нөхцлүүдийг тодорхойлох, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх олон нийтийн хандлага, санал бодлыг шинжлэх, дүүргүүдийн засаг захиргааны байгууллагуудаас хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдвэрлэх талаар ямар арга хэмжээ авч байгааг судлах зорилгоор Улаанбаатар хотын 6 дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг Наран Туул, Хар Хорин, Барс, Техник Импорт, Баянзүрх, Цайз, Да Хүрээ, Хангай, 100 айлын, Бөмбөгөр, Хүчит Шонхор зэрэг захууд дээр хөдөлмөр эрхэлж буй 300 хүүхдийг хамруулан судлав.

## Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн дийлэнх нь 16 нас хүрээгүй хүүхдүүд байна

**Зах дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн нас**

Насны бүлэг	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
8 хүртэлх	0.5	0.9	0.7
8-12	29.5	30.8	30.0
13-15	50.3	57.9	53.0
16-18	19.7	10.3	16.3
	100.0	100.0	100.0
Дундаж нас	13.6	13.2	13.4

Зах дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 84 орчим хувь нь 16-аас доош насны хүүхдүүд бөгөөд

хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 64 хувь нь эрэгтэй хүүхдүүд байна. Хүүхдүүдийн 60 орчим хувь

нь сургуульд суралцдаггүй байна. Хүүхдүүд ихэвчлэн өрхдөө орлого оруулах зорилгоор, хичээлийн хэрэгсэл, хувцас авах мөнгөгүйн улмаас сургуульд суралцахгүй байна. Бүртгэлгүй тул сургууль авдаггүй гэж хүүхдүүдийн 21 хувь нь хариулж байна.

## Хүүхдүүд юу хийж байна вэ?

Дээрх захуудад ойролцоогоор 1000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлж байна. Хөвгүүд голдуу тэрэгтэй болон тэрэггүй ачаа бараа зөөх, машин харах,

угаах ажил хийдэг бол охид хүнсний хаягдал цуглувж зарах, жижиг бараа, хоол цай, жимс, самар зарах ажил хийдэг байна. Хүүхдүүд мөн модны зах дээр банс буулгах,

хүнсний захын хүйтэн зооринд ногоо ялгах, өглөө, оройд зах нээх, хаах үед ачаа бараа буулгах, орой зах тарсны дараа цэвэрлэх зэрэг ажил голдуу хийж байна.

## Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн ар гэрийн байдал

Хөдөөнөөс шилжиж ирээд зах дээр ажиллаж байгаа хүүхдүүдийн 42 хувь бүртгэлгүй өрхөд амьдарч байна. Хүүхдүүдийн 88 хувь нь гэрт болон байшинд, 6 хувь нь орцны жижүүрийн байр, амбаарт амьдардаг эсвэл орон гэргүй ажээ. Өрхийн ам бүлийн дундаж

тоо 5.7 байгаа нь улсын дунджаас 1.4 пунктээр өндөр байна. Хүүхдүүдийн гуравны нэгээс илүү нь хагас өнчин, өнчин хүүхдүүд байна. Аавтайгаа эсвэл ээжтэйгээ амьдарч байгаа хүүхдүүдийн аав, ээжүүдийн 17.3 хувь нь тахир дутуугийн группэд байдаг байна.

Шилжин ирсэн айлын хүүхдүүдийн хувьд зах бол нүүж ирсэн айлын түгжигдмэл амьдралаас түр ч гэсэн гарч, олон хүнтэй харилцах, өдрийг хөгжилтэй өнгөрөөх газар болдог байна.

## Хүүхдүүд дулааны улиралд илүү олон цагаар ажилладаг

Хүүхдүүд голдуу өөрийн сонирхлоор эсвэл эцэг эх, хамаатнуудын санаачилгаар хөдөлмөр эрхэлж эхэлдэг байна. Тэдний 44 хувь нь зах дээр байнга хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд. Хүүхдүүд зүн, хаврын улиралд хамгийн олон цагаар буюу

өдөрт дунджаар 9 цаг, өвөл намрын улиралд дунджаар 5 цаг ажилладаг. Ажлын өдрийн дундаж тоо долоо хоногт 5,5 хоног байна. Хүүхдүүдийн 30 хувь нь бүтэн долоо хоногийн турш амралтгүй ажилладаг, талаас илүү нь ажлынхаа

дундуур амарч чаддаг ч гэсэн хүүхдийн нас томрох тусам амрах цаггүй, олсон ажлаа алдахгүй гээд огт амралтгүй ажилладаг байна. Ажлын дундуур амралтаараа хүүхдүүдийн ердөө 29 хувь нь хоол иддэг ажээ.


## Хүүхдүүд бохир орчинд, мөн эрүүл мэндийн эрсдэлтэй ажиллаж байна

Хөдөлмөрийн улсын байцаагчийн үнэлж буйгаар зах дээр хүүхдүүд байнгын бохир, утас угаартай, тоосжилттой, халуун хүйтэн нөхцөлд ажиллаж байна. Үүнийг тодруулбал:

- халуун хүйтэн нөхцөл (өвөл, зуны улиралд

Ажил хийж байхдаа өвчилж байсан хүүхдүүдийн хувийн жин, насаар

- байнга гадаа ажилладаг)
- тоосжилттой орчин (олон хүн холхих, захын талбай цэвэрлэх, төмс хүнсний ногоо ялгаж, сортлох үед тоос шороо их байдаг)
  - утас, угаар, хорт хийгээр амьсгалах, (зах дээр их хэмжээний машин, тэрэг цуглах үед машины утас агаарт ихээр байдаг)



Хүүхдүүд зах дээр өлөн зэлмүүн байдалтай хүнд ажил хийж байгаа нь тэдний биеийн дархлаа, эсэргүүцэл суларч, ажлын бохир орчноос амархан халдварт авах, өвчин тусах эрсдэлтэй байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 45.3 хувь нь ажил хийж байхдаа ямар нэг өвчин тусч байснаас эдгээр нь амьсгалын замын, дотор эрхтний, тархи мэдрэлийн системийн, үе мөчний, халдварт болон арьс өнгөний өвчлөлүүд байжээ.

Хүүхдүүдийн 39 хувь нь гэмтэл бэртэл авч байснаас 13-15 насны хүүхдүүд илүүтэй өртсөн байна. Голдуу гар хөлөө хугалж, гэмтээхээс гадна тархи толгой, нуруу, үе мөчөө гэмтээх тохиолдлууд ч байна. Гэмтэл авсан хүүхдүүдийн 34 хувь нь л эмч эсвэл бария засалчид очсон байна.

Тэрэг түрж буй хүүхдүүд 16-18 насных голдуу байгаа хэдий ч заримдаа 16 хүртэл насны хүүхдүүд байна. Тэргээр ачаа зөвхөн буй хүүхдүүдийн ачаа нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 8-10 дахин, гараар зөвхөн буюу үүрч буй ачаа нь тогтоосон нормноос 4-5 дахин хүнд байна.

... Сая таныг ирэхийн өмнө би банзанд өлгөгдсөн. Манай найз намайг аварсан. Хүнд банзандаа дийлдээд яг үхэх гэж байсан. Оогий банзынхаа үзүүрийг дараагүй бол яг үхэх байсан . . .

(О.14 настай. эрэгтэй. Хангай зах)

Зоорини ногоо ялгах ажлыг голдуу охидууд хийдэг бөгөөд энэ нь хүйтэн, тоостой нөхцөлд хийгдэж байна. Нойтон зузаан бансыг буулгаж, хураахад маш их хүч шаардагддаг, ядардаг байна. Нийт хүүхдүүдийн 56 хувь нь өөрийн хийж буй ажлаа хүнд ба хүндэвтэр гэж тодорхойлж байна. Хүүхдүүд ажлын нөхцлөөс өөрт нь нөлөөлж байгаа сөрөг нөлөөллийн талаар мэдлэггүй, өдрийн хоолныхоо мөнгийг олж л байвал боллоо гэсэн ойлголт түгээмэл байна.

Хүүхдүүдийн 40 гаруй хувь нь л өвдсөн үедээ эмнэлэгт ханджээ. Тэдний 69.3 хувь нь эрүүл мэндийн даатгалтай, 16-18 наснындаа даатгалгүй хүүхдийн эзлэх хувь 30.9 хувь буюу хамгийн өндөр байна. Үүний зэрэгцээ хүүхдүүд наиз нөхдийнхөө нөлөөнд орж тамхи, архи хэрэглэж сурч байна. Тэд дунджаар 12 насандаа анх тамхи татаж үзсэн эсвэл татаж эхэлсэн, 14 насандаа анх архи хэрэглэж үзжээ. 15-аас дээш насны хөвгүүдийн гуравны нэг нь тамхи байнга татдаг байна.

## Орлогоо хэрхэн зарцуулдаг вэ?

Хүүхдүүдийн 10 хувь нь өдөрт 500 хүртэл, 40 орчим хувь нь 1500 хүртэл, 50 орчим хувь нь 1500-аас дээш төгрөгний орлоготой ажилладаг ажээ. Орлогоороо гэртээ хүнс худалдаж авдаг, эсвэл мөнгөө шууд аваачдаг байна. Олсон орлого нь өрхийн амьжирагаанд нь боломжийн нэмэр болдог гэж нийт хүүхдүүдийн 54.5 хувь нь хариулжээ.

... Би лав гэртээ л юм авдаг. Мөнгө аваад очиход ээж хамгийн их баярладаг...

(Х. 14 настай. эрэгтэй, Хангай зах)

## Хүүхдүүд орлогоосоо хураамж төлдөг

Хүүхдүүдийн 27.3 хувь нь олсон орлогоосоо ямар нэг байдлаар хураамж төлдөг ажээ. Давхардсан тоогоор хүүхдүүдийн 74.4 хувь нь захын байцаагч нарт, 29.3 хувь нь атаманд, 4.9 хувь ажил олгодог хүндээ, мөн 4.9 хувь нь цагдаад өгдөг ажээ. Хүүхдүүд сард дунджаар 26250 төгрөг, өдөрт 1048 төгрөгийн хураамж төлдөг гэж тооцоолж байна. Үүний зэрэгцээ тодорхой бүлэглэлийн хүүхдүүд зах дээр ажил хийж буй хүүхдүүдээс мөнгө татаж, айлан сурдүүлж дарамталдаг байна.

... Ихэнхдээ бүлэг болгон бие биенээ дээрэлхдэг. Архи уудаг, хармаан суйлдаг, ногоо хулгайлдаг гээд олон төрлийн бүлэг байдаг. Хувцас дээрэмддэг, өгөхгүй бол зоддог...

(Г.12 настай, эрэгтэй, Дэнжийн мянгын зах)

Хүүхдүүд үйлчлүүлэгчид зүй бусаар харьцах, осол гэмтэлд өртөх, хулгайлдад орлогоо алдах, дээрэмдүүлэх, бусдад дээрэлхүүлж дарамтуулах, захын байцаагчид, цагдаа, томчууд зүй бусаар харьцах зэргийг хамгийн түгээмэл тохиолддог бэрхшээлүүд гэж үзэж байна. Зах дээр ажилладаг цагдаагийн болон захын захиргааны ажилтнууд хүүхдийг нэн түрүүнд буруутгаж, хураамж авснаар хэргийг шийдэх амар арга болгодгийг хүүхдүүд ярьж байна. Бэрхшээл тохиолдсон үед дунджаар хүүхдүүдийн 40 хувь нь л бусдаас тусламж гүйж, тэдний 2/3 орчим нь тусламж авч чаджээ.

Тэдний ойрын ирээдүйн зорилго бол ажил хийж мөнгө олох, боловсрол мэргэжилтэй болох явдал байна.

Охидын 70 орчим хувь нь сургуульдаа эргэн сурахыг хүсч байгаа, ялангуяа насын бүлэг ахих тусам энэ хүсэл нь нэмэгдэж байгаа нь нас ахих тусам охидын өөртөө болон амьдралд хандаж буй хандлага нь өөрчлөгдж байгааг харуулж байна.

Тэднийг ажил хийе гэхээр насанд хүрээгүй, боловсролгүйгээс гадна дийлэнх нь бичиг баримтгүй ажээ. Тэдэнд бусад

хүмүүс итгэдэггүй, харахаараа цэрвэх, зугатах, төвөгшөөх явдал олонтаа гардаг байна. Хэдийгээр охид ажил хийж, мөнгө олохыг илүүд үзэж байгаа ч тэд өөрсдийгүй хайлаж, хамгаалах дотны хүмүүсгүй тул тэдний туйлын хүсэл нь эцэг эх эсвэл хэн нэгэн хүн тэднийг хайлаж халамжлаасай, тэднийг хамгаалдаг байгууллага юуны түрүүнд байгаасай гэж хүсдэг байна.

Охидын зарим хэсэг нь нэгэнт л ийм замд орсон, тиймээс аль болохоор дээд зиндаагаар явахыг эрмэлзэж байгаагаа ч илэрхийлж байв.

### Бодлогын зөвлөмж

- Насанд хүрээгүй охидыг биеэ үнэлэхэд зуучилж, зохион байгуулж буй этгээдүүдийн үйл ажиллагааг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг эрчимжүүлэх
- Тэднийг худалдан авч үйлчлүүлж байгаа хүнтэй хариуцлага тооцох тухай хуулийн заалтуудыг боловсронгуй болгох
- Охидыг эрх зүйн хүрээнд хамгаалах, улмаар тэд зуучлагч нартай биш, хуулийн байгууллагатай хамтарч ажилладаг болоход чиглэсэн зохицуулалтыг боловсронгуй болгох
- Хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд сэтгэл зүйн сэргээн засал хийх үйлчилгээг бий болгох
- Биеэ үнэлсэн болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдтэй (ялангуяа сэтгэл зүйн талаас нь) ажиллахад цагдаагийн ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх
- Эдгээр охидын эрүүл мэндийг нөхөн сэргээх, боловсрол олгох, мэргэжлийн сургалтанд хамруулах замаар эрхийг нь сэргээх, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэхийг дэмжих ажлыг орон нутгийн түвшинд холбогдох төрийн ба төрийн бус байгууллагуд зохицуулалттайгаар хэрэгжүүлдэг болох

## Биеэ үнэлж байгаа болон үнэлэх эрсдэлтэй охидын судалгаа

Судалгаа хийсэн байгууллага:

МУИС-ийн Хүн Ам Зүйн Сургалт,  
Судалгааны Төв

Судалгаа хийсэн он:

2001 он

Хамрагдсан газар :

Улаанбаатар хот

Судалгаагаар насанд хүрээгүй биеэ үнэлж байгаа болон үнэлж болзошгүй эрсдэлд байгаа охидын нөхцөл байдал, тэд хэрхэн биеэ үнэлдэг, учирдаг бэрхшээл, биеэ үнэлэх явдалд зуучлан ашиг ологчдын шинж байдлыг тодорхойлох зорилгоор биеэ үнэлж буй<sup>1</sup> болон биеэ үнэлэх эрсдэлд байгаа<sup>2</sup> 13-18 насын 66 охидыг хамруулав. Судалгаанд зөвхөн гэрээсээ дайжсан ба дайжих эрсдэлтэй хүүхдүүд хамрагдсан болно.

### Биеэ үнэлж буй болон эрсдэлтэй охидын байдал

Судалгаанд оролцсон охидын гуравны хоёр нь гэр булийн зөрчил, бусдын нөлөөнд автан, эсвэл эцэг эх, ах эгч нар нь зоддог гэсэн шалтгааны улмаас орон гэрээсээ дайжжээ. Ялангуяа бага насын охид ах эгч нар нь зодсоны улмаас гэрээсээ дайжсан нь илүүтэй байна.

Боловсролын түвшин	Насны бүлэг		
	13-14	15-16	17-18
Огт боловсролгүй	75.0	38.5	28.6
Анхан шатны	25.0	61.5	64.3
8-р анги	0.0	0.0	7.4
Бүгд	100.0	100.0	100.0

Охидын 70 орчим хувь нь сургууль завсардсан, 10 гаруй хувь нь сургуульд огт хамрагдаж байгаагүй ажээ. Эцэг эхийн хараа хяналт сул, анхаарал халамж муу, гэр булийн зөрчил их, хүүхэд хүмүүжүүлэх эцэг эхийн арга зүй дутагдалтай байдал зэрэг нь охидыг орон гэрээсээ дайжихад хүргэдэг байна.

<sup>1</sup> Биеэ үнэлэгч охид гэдэгт мөнгө харамж авах зорилгоор болон зуучлагчийн хүчинд автаж бэлгийн харьцаанд орж буй 18 ба түүнээс доош насын охидыг оруулсан.

<sup>2</sup> Биеэ үнэлэх эрсдэлд байгаа охид гэдэгт хүчирхийллээс болоод гэр ороосоо дайжсан, орлогогүй, эсвэл гудамжинд ихээхэн цагийг өнгөрөөдөг охидыг хамруулсан.

Биеэ үнэлэгч охидын 57.5 хувь нь 13-16 наасны, 42.5 хувь нь 17-18 наасны охид байна. Охидын 48.5 хувь нь олсон орлогоо хүнсэнд, 36.4 хувь нь өөртөө хэрэгтэй зүйл худалдан авахад зарцуулдгаас харахад тэд хоногийн хоолоо олж өдөр хоног өнгөрөөхийн тулд биеэ үнэлэх замд татагдан орж байгааг илтгэж байна. Тэдний эцэг эхчүүдийн дийлэнх нь ажилгүй, мэргэжлийн боловсрол,

ур чадвар доогуур хүмүүс байна. Охидын тавны нэг нь өөрийн гэсэн гэр оронгүй айлын хүүхдүүд байв. Орон гэртэй гэсэн охидын 63 хувь, орон гэртэй гэсэн охидын 88 хувь нь траншей, орц, гудамжинд, 16 хувь нь айлд амьдарч байгаа ажээ. Траншей, гудамжинд амьдарч байгаа охидын дотор 13-14 наасны охидын эзлэх хувь илүү өндөр байна.

## Зуучлагчид охидыг биеэ үнэлэхэд татан оруулж байна

Биеэ үнэлэх явдалд охид эхлээд бусдад уруу татагдан эсвэл хүчинд автан ордог бөгөөд дараа нь зуучлагч нараар дамжуулан биеэ үнэлдэг болдог ажээ. Ихэнх охид хүчинд автан явдаг байна. Сайн дураараа биеэ үнэлдэг охид байдаг бөгөөд тэд голдуу боломжийн айлын хүүхдүүд байдаг байна.

Судалгаанд хамрагдсан охидын 18.2 хувь нь өөрсдөө орлогоо шууд авдаг, 24.2 хувь нь зуучлагчаар дамжуулан мөнгө авдаг, үлдсэн 57.8 хувь нь хариулт өгөхөөс татгалзан зуучлагчаа нуух хандлага ажиглагдаж байв. Зуучлагчид нь бүлгээрээ байдаг ба сүүлийн үед нэг гэр бүлийн ах дүү нар зуучлагч хийх нь элбэг болжээ. Мөн хөвгүүдийг зарах явдал ч гарчээ.

... Охидыг зуучлагч нарын ихэнх нь ах дүү хүмүүс байдаг. Жишээлбэл том M, жижиг M нар 22-26 наасны эгч дүү нар, N, A, Y, B, D, B.. нар бүгд ах дүү нар.

Эмэгтэйчүүд нь бага байхдаа бүгдээрээ биеэ үнэлдэг байсан, одоо охидыг зуучлах ажлыг ах дүү нартайгаа хамт хийдэг...

(А-гийн ярианаас)

Зуучлагч, үйлчлүүлэгч нар нь насанд хүрээгүй хүүхдийг зарах, худалдан авах үйл ажиллагаанд оролцож байгаа тул өөрсдийн үйл ажиллагааг зохион байгуулалтанд оруулан нууцаар явуулж байна.

... Насанд хүрээгүй хүүхэд бие дааж мөнгөө тохиролцож чаддагуй, томчуудтай харьцуулахад хүний угэнд оромтгой, дуулгавартай, хуурахад амархан байдаг, хамгаалагчгүй бол үйлчлүүлэгч нь зүй бусаар харьцдаг тул охид зуучлагчаар дамжин биеэ үнэлэхийг илүүд үздэг... Ихэнх үйлчлүүлэгчид нь тусгай зочид буудлуудад очдог. Тусгай байрууд маш нууцлагдмал энэ тухай зөвхөн зуучлагч нар л мэддэг. Зарим буудлууд зуучлагч нартай тохиролцсон байдаг ба тэдэнд бүр тусгай тарифаар үйлчилдэг...

(Г. ЭЦГ-ын ажилтан)

## Охидын дийлэнх нь эрүүл мэндийн байдлаа үнэлж мэдэхгүй байна

Охидын тал хувь нь өөрийнхөө эрүүл мэндийн байдлыг тодорхойлж мэдэхгүй, ялангуяа охидын амьдралын түвшин нь ядуу болох тусам өөрийн эрүүл мэндийн байдлаа тодорхойлж мэдэхгүй байна. Зарим охид жиремсэлж байсан бөгөөд тэд БЗХӨ-өөр байнга өвдөж, өвчнийг эмчлээд явуулсан ч бэлгэвч огт хэрэглэдэггүйн улмаас богино хугацаанд дахин халдварт авдаг байна.

... Хараа хяналтгүй хүүхдүүдийн төв байраар дамжин өнгөрч буй хүүхдүүдэд эмчийн үзлэг хийхэд ихэнх нь өвчтэй байдаг. Өвчлөлд нэгдүгээрт, бэлгийн замын халдварт өвчин, хоёрдугаарт арьсны өвчин, гуравдугаарт гэмтэл зонхилж байна...

(Э. Хараа хяналтгүй хүүхдүүдийн төв байрны их эмч )

Охид найз хөвгүүн эсвэл бусдын ятгалгаар, танихгүй хүн, хойд эцэг, төрсөн эцэгтээ хүчиндүүлсэн, тэнэмэл, орон

гэрээсээ дайжсаны улмаас болон мөнгөтэй болох зэрэг шалтгаанаар анх бэлгийн харьцаанд оржээ.

## Тэд хүчирхийлэлд байнга өртөж, сэтгэл зүйн хувьд өөрчлөлтөд ордог

Охидыг худалдаж авдаг хүмүүс хэрцгий, хүчирхийлж харьцах нь олонтаа ажээ. Судалгаанд оролцсон охидын 57.1 хувь нь үйлчлүүлэгчид зүй бусаар харьцах байсан, 42.3 хувь зодож, сурдүүлж байсан, 39.3 хувь нь доромжилж байсан (давхардсан тоогоор) гэжээ.

Охидын ихэнх нь амьдрахын эрхээр, эсвэл хүчинд автан биеэ үнэлж байгаа нь тэдний сэтгэл зүйд хүнд гэмтэл, онцгой

өөрчлөлт оруулдаг байна. Охидод өөртөө итгэх итгэл үнэмшил бараг байхгүй, ялангуяа хүчинд автан биеэ үнэлсэн охид сэтгэл зүйн гүн хямралд ордог байна. Үүний зэрэгцээ тэд худал ярих, залиах зэрэг зан харьцааны доголдолд ордог ажээ. Тэдний ихэнх нь эцэг эхдээ ихэд гомдож явдаг, учир нь эцэг эх нь тэднийг хэзээ ч бусдаас хамгаалж хайлрадаггүй, харин ч биеэ үнэлдгээр нь дуудан, гэрээсээ хөөдөг байна.

## Хүчирхийлэл эргээд хүчирхийллийг төрүүлэх магадлалтай байна

Гэрээсээ 5-6 жил дайжин гадуур тэнэн амьдарсан охид өөрсдийн туулж өнгөрүүлснээ шинээр гудамжинд гарч буй хүүхдэд тулган хүчирхийлэгч болон хувирдаг ажээ. Удаан хугацаагаар гадуур тэнэж байгаа ахлах наасны охид сүүлийн үед охид зуучлах ажилд оролцох болсон байна. Тэд анх бусдын хүчинд автан биеэ үнэлж байсан бол нас ахиад ирэхээр гудамжинд шинээр гарч ирж байгаа охидыг зуучилж эхэлдэг

байна. Эндээс үзвэл хүчирхийлэлд өртөж байсан хүүхэд эргээд хүчирхийлэгч болох магадлалтай байна.

... Бага насыхан голдуу чихээсэнд явдаг. X, M, C, Z гэдэг охидууд бага байхдаа чихээсэнд явдаг байснаа харин одоо охидыг зардаг болсон. Тэд хашаа байшин хөлсөлж бөөнөөрөө амьдардаг...

(Э. Хараа хяналтгүй хүүхдийн халамжийн төв)

## Охидын ирээдүйнхээ талаарх бодол

### Охидын ирээдүйн хүсэл эрмэлзэл



Охидын 76 хувь нь биеэ үнэлэхийг огт хүсдэггүй, маш муухай санагддаг, их зовлонтой гэж хариулж байна. Тэдний 88 хувь нь биеэ үнэлэх замаар бий болох тодорхойлж мэдэхгүй байна. Зарим охид жиремсэлж байсан бөгөөд тэд БЗХӨ-өөр байнга өвдөж, өвчнийг эмчлээд явуулсан ч бэлгэвч огт хэрэглэдэггүйн улмаас богино хугацаанд дахин халдварт авдаг байна.